

**ГАДААДЫН ИРГЭН ХАРЬАТЫН ГАЗРЫН САНХҮҮ ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2024 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Төсөв санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах							
1.	Арга хэмжээ 1.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөж батлуулах, зориулалтын дагуу зарцуулах	Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн	17.5 тэрбум	17 тэрбум	Энэ оны дөрөвдүгээр улирлын байдлаар 15,818.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 12,608.2 сая төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллалаа. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01, 02, 05, 10, 11, 12 дугаар саруудад 01/177, 01/865, 01/1082, 01/1888, 01/2140, 01/2361 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлыг шийдвэрлүүлсэн. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөж, 01/1400 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд 2025 оны урсгал зардлыг 23.3 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 2.4 тэрбум төгрөг, нийт төсвийг 25.7 тэрбум төгрөгөөр төлөвлөн, төсвийн төлөвлөлтийн Fiscal.B цахим системд шивж, Хууль зүй, дотоод хэргийн сайд болон бусад албаны хүмүүст 07 дугаар сарын 20-ны өдөр танилцуулсан.	I-XII	100
2.	Арга хэмжээ 1.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансыг нэгтгэн, холбогдох	Зөвлөмж, акт, албан шаардлага авсан эсэх (өсөлт бууралт)	6/1/3	6/1/3 бууруулна	Төв болон орон нутаг дахь газар, хэлтсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлбар, тодруулгын хамт энэ оны 01/491 дугаар албан	I-XII	90

	байгууллагаар аудит хийлгэж, тайлбар гаргах;	санхүүгийн тодруулга,				бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох баримт материал болон судалгааг хугацаанд нь гаргаж өгч ажилласан. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газарт амжилттай шалгуулж, "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч ажилласан. 7/0/2 (7 зөвлөмж, 2 төлбөрийн акт)		
3.	Арга хэмжээ 1.3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	Баталгаажуулж хүргүүлсэн тайлан, мэдээний тоо	12	12	- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн 2023 оны 12, 2024 оны 01, 02, 03, 04, 05, 06, 07, 08, 09,10,11 дүгээр сарын мэдээг нэгтгэн ХЗДХЯ-нд сар бүрийн 02-ний өдөр хүргүүлж баталгаажуулсан. - 2024 оны цалин хөлсний судалгааг гаргаж, 01/552 албан бичгээр; - Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого болон холбогдох эрх зүйн актын судалгааг 03 дугаар сарын 06-ний өдрийн 01/500 тоот албан бичгээр; - 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн өглөг авлагын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, 09 дүгээр сарын 27-ний өдөр цахимаар тус тус ХЗДХЯ-нд хүргүүлсэн. - Албан хаагчдын цалин хөлсний нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүр буюу 11 удаа, ХХОАТ-ын тайлан болон бусад татварын тайланг улирал бүр буюу 3 удаа, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг хагас бүтэн жилээр буюу 2 удаа хугацаанд нь тайлагнаж баталгаажуулсан.	I-XII	100	
4	Арга хэмжээ 1.4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Худалдан авах ажиллагааны 2024 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	97.5	100	2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 төсөл арга хэмжээний шалгаруулалтыг tender.gov.mn цахим хуудсаар нээлттэй зарласан.	I-XII	70	

	зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллах.				<u>Хөрөнгө оруулалт:</u> - Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын /Ховд, Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендэрт шалгарсан Элбэггүн ХХК-тай гэрээ байгуулж, гэрээт ажлыг 100 хувь гүйцэтгэсэн тул барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын акт болон бусад холбогдох баримт материалыг ХЗДХЯ-нд хүргүүлэн хянуулж байна. <u>Урсгал зардал:</u> - Урсгал засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Өнөших трейд" ХХК, "Улсын мэдээллийн маягт бэлтгэх, хэвлэх" үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан "Нью компас" ХХК, "Тээвэр шатахуун" нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Шунхлай трейдинг" ХХК, "Интернэт болон сувгийн холболт" үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан "Мобинет" ХХК-тай гэрээг тус тус байгуулж, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавин, гэрээ дүгнэсэн актын дагуу санхүүжилтийг олгоод байна. - Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс "Багаж техник хэрэгсэл" худалдан авах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Саммит компьютер технологи, Ай ти зон ХХК-тай гэрээг байгуулж, багаж техник хэрэгслийг актаар хүлээн авч, санхүүжилтийг олгосон. - Нормын хувцас болон мэдээлэл технологийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 тендерийг зарлалгүй төсвийн хэмнэлтээр тайлагнасан бөгөөд 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг 01/2412 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлээд байна. Байгууллагын 2024 оны ХАА-ны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.		
--	--	--	--	--	---	--	--

5	Арга хэмжээ 1.5. Тэмдэгтийн хураамж, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавих, тайлан гаргах, үнэт цаасны тайланг нэгтгэх, тооцоо нийлэх;	Төвлөрүүлсэн орлогын дүн	14.1 тэрбум төгрөг	8 тэрбум төгрөг	Энэ оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 22.6 тэрбум төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 2.0 тэрбум төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж, орлого төвлөрүүлэлтэд сар бүр хяналт тавьж ажилласан.	I-XII	100
6	Арга хэмжээ 1.6. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд төвлөрүүлж буй нэмэлт орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавих	Төвлөрүүлсэн орлогын дүн, хяналт тавьж ажилласан тоо	1.1 тэрбум/2	1.1 тэрбум/2	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд визийн үйлчилгээний хөлс, оршин суух үнэмлэх хэвлэх хураамжийн орлого болох 2.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, орон нутаг дахь нэгжүүдийн орлого төвлөрүүлэлтэд сар бүр хяналт тавьж ажиллалаа.	I-XII	100
7	Арга хэмжээ 1.7. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан тэнцлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах;	Байгууллагын эд хөрөнгийн тоо, үнийн дүн, тооцоо нийлсэн акт, бараа материал, эд хөрөнгийн тайлан	7.9 тэрбум төгрөг/7/95	7.9 тэрбум төгрөг/7/95	2023 оны жилийн эцэс, 2024 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулан 22 байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулсан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор 6.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, 1.5 тэрбум төгрөгийн бараа материалыг тоолж, данс бүртгэлтэй тулгалт хийн баталгаажуулсан. Эд хариуцагчийн 8 дансны тайланд сар бүр буюу 11 удаагийн хяналт тавьж баталгаажуулан, нийт 1,530,9 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 1,930,2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулаад байна. Энэ оны дөрөвдүгээр улирлын байдлаар төсвийн хөрөнгөөр худалдан авсан 211.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч бүртгэл тайланд тусгаад байна. <u>Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хийгдсэн хөрөнгийн хөдөлгөөн:</u>	I-XII	90

				- Ашиглалтын шаардлага хангахгүй, цаашид ашиглах боломжгүй 871 ширхэг 30.2 сая төгрөгийн бараа материалыг акталсан; - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 232 дугаар тогтоол, байгууллагын даргын А/213 дугаар тушаалын дагуу 1,007.6 төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон; - ТӨБЗГ-ын 458 дугаар тогтоол, байгууллагын даргын А/479 дугаар тушаалыг үндэслэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын засаг даргын Тамгын газраас 475,5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж авсан; - ТӨБЗГ-ын А-1/1642 тоот албан бичиг, байгууллагын даргын А/416 тоот тушаалын дагуу хилийн боомт орон нутаг дах нэгжүүдэд 207,1 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн; <u>Холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн санал:</u> Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар ашиглалтын хугацаа дууссан, үлдэх өртөггүй хөрөнгийн саналыг хэлэлцэж, дараах саналыг холбогдох дээд байгууллагад 01/2216, 01/2243, 01/2273 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: - Цаашид ашиглах боломжгүй 159,3 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг актлах; - Цаашид ашиглах боломжтой 858,9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ болон ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох; - Цаашид ашиглах боломжгүй 32,1 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаанд оруулах;		
--	--	--	--	---	--	--

					- 4 ширхэг 444,9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 73 ширхэг 20,1 сая төгрөгийн балансын үнэтэй тавилга эд хогшил, 70 ширхэг 156,4 сая төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмжийг төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд балансаас балансад шилжүүлэх; - 3 ширхэг 1,5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Татварын ерөнхий газарт, 96 ширхэг 14,6 сая төгрөгийг тавилга эд хогшлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнд балансаас балансад шилжүүлэх;		
8	Арга хэмжээ 1.8. Боомт орон нутаг дахь нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл хүргүүлж ажиллах;	Хүргүүлсэн чиглэл, хяналт тавьж ажилласан тоо	3/4	3/3	- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахтай холбогдуулан Төв болон боомт орон нутаг дахь нэгжүүдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргалтад хяналт тавьж, алдаа зөрчлийг засах чиглэлийг тухай бүр хүргүүлж, жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан. - Боомт, орон нутаг дахь нэгжүүдээс ирүүлсэн 2025 оны төсвийн хязгаарын санал болон төсвийн төслийг хянаж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн хязгаарын саналыг 01/1124 тоот албан бичгээр, 2025 оны төсвийн төслийг 01/1400 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. - Өмнөд бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааг хамруулсан бөгөөд өмнө илэрсэн 12 зөрчлийн хүрээнд холбогдох баримт материалыг нягтлан, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. - Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын 2024 оны 1-3 дугаар сарын цалин бодолтыг шалгасан.	I-XII	100
	Арга хэмжээ 1.9.Төв, боомт, орон нутаг дахь нэгжид Шилэн	Цахим хуудсанд байршуулж,	149	149	shilendans@mof.gov.mn цахим хуудаст - Сар бүр оруулах 44,	I-XII	100


	дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хуулийн хугацаанд мэдээллийг оруулахад хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах	албан хаагчдад болон олон нийтэд мэдээлсэн мэдээллийн тоо			- Жил бүр оруулах 13, - Тухай бүр оруулах 110, Нийт 163 мэдээг хуулийн хугацаанд байршуулж ажилласан. Орон нутаг дахь нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2 удаа хяналт тавьж ажилласан.		
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, албаны үйл ажиллагааг хэвийн явуулахад албан хаагчдад шаардлагатай ажиллах орчин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах							
1	Арга хэмжээ 2.1. Албан хаагчдын ажиллах хэвийн нөхцөлийг хангах зорилгоор цэвэрлэгээ, үйлчилгээг стандартын дагуу тогтмол хийж гүйцэтгэх;	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	- Үйлчилгээний албан хаагчдын цэвэрлэгээ үйлчилгээний хуваарийг шинэчлэн гаргаж, цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулахаар үнэлгээний хуудсыг өрөө тасалгаа бүрт тараан олгож, үр дүнг тооцохоор зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан бөгөөд цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанартай хийж гүйцэтгэсэн. - Албаны байрны дээврийн цасыг буулгаж зөөвөрлөх, гадна талбайн мөс, хог хаягдлыг цэвэрлэх, байгууллагын эзэмшлийн талбай болон нийтийн эзэмшлийн 50 м газрыг тогтмол цэвэрлэн, хог хаягдлыг Хан-Уул дүүргийн Биокомбинатын хогийн цэгт устгалд оруулж, цэвэрлэгээ хийсэн тухай илтгэх хуудсыг 21-р хорооны холбогдох албан тушаалтанд цаг тухайд нь явуулж ирсэн.	I-XII	100
2	Арга хэмжээ 2.2. Байгууллагын тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, эвдрэл, гэмтлийг засварлах;	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтад өдөр тутмын хяналт тавьж, "А" байрны 1, 2 дугаар давхарт 3 ширхэг хаалга, "Б" байрны 3-р давхарт 6 ширхэг хаалгыг худалдан авч суурилуулах, спорт заалны 5 хаалгыг модоор амлагаа бэхэлгээ хийн засварлан сайжрууллаа. Тавилга эд хогшлыг угсрах, засварлах ажлыг тухай бүр гүйцэтгэж ажилласан.	I-XII	100
3	Арга хэмжээ 2.3. Байгууллагын цахилгаан, дулаан, сантехникийн шугамд хяналт тавих, засвар үйлчилгээ хийх, доголдлыг арилгах;	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	2024 оны 05 дугаар сарын 15-аас байгууллагын халаалт зогссонтой холбогдуулан цэвэр ус, халаалтын шугам хоолойд үзлэг хийн 8 метр хэрэглээний цэвэр усны шугам, халуун хүйтэн усны 2 ширхэг хаалт солих, дулааны автомат тоолуур баталгаажуулах, ялтсан фойлуур угаах, хэрэглээний цэвэр ус, гадна дулааны шугам хоолойд даралт өгч битүүмжийг шалгах, үзель дэх сантехникийн шугамнуудад дулаалга хийх зэрэг ажлуудыг	I-XII	100

					Улаанбаатар дулааны цахилгаан станцын инженерүүдийн хяналтан дор хийж гүйцэтгэсэн.		
4	Арга хэмжээ 2.4. Барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих, урсгал засварыг төлөвлөлтийн дагуу хийлгэх;	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100.	Барилга байгууламжийн ашиглалтад өдөр тутмын хяналт тавьж, "А" байрны албан хаагчдын хувцас солих өрөөний 12м2 шал солих, хана, тааз буулгаж, засварлах, 304 тоот өрөөний 54м2 шал, 308 тоот өрөөний 36м2 шал солих, тааз буулгаж, засварлах, автобусны граж, автомашины нэгдсэн гражийн дээврийн засвар зэрэг урсгал засварын ажлыг үйлчилгээний албан хаагчид хийж гүйцэтгэсэн бөгөөд А, Б байрны гадна фассад, спорт заалны шалны засварын ажлын санхүүжилтийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.	I-XII	100
5	Арга хэмжээ 2.5. Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, албан хаагчдад шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үйлчлэх;	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Нийслэлийн нийтийн тээврийн газрын оношилгооны төв болон Сонгинохайрхан дүүргийн тээврийн хэрэгслийн оношилгооны төвд тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношлогоонд бүрэн оруулж, замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг сунгуулах, жолоочийн хариуцлагын даатгалд хамруулах, хавар, намрын техникийн үйлчилгээнд бүрэн хамруулж, тос масло, маслын шүүр, моторын болон салоны агаар шүүгч солиулах, шаардлагатай сэлбэг хэрэгсэл худалдан авч засвар үйлчилгээг хийх зэрэг техникийн үйлчилгээг хийлгэн замын хөдөлгөөнд оролцох бэлэн байдлыг хангаж ажилласан.	II, IX	100
6	Арга хэмжээ 2.6. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор спортын уралдаан тэмцээн, бусад арга хэмжээ зохион байгуулах, салбарын тэмцээн, уралдаанд баг тамирчдыг оролцуулах;	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	"IMMIGRATION СПОРТ НААДАМ 2024" спортын тэмцээн болон ХЗДХЯ-ын спортын 4 төрөлт тэмцээнд бэлтгэл ажлын хүрээнд албан хаагчдыг бэлтгэл сургуулалт хийх нөхцөл боломжоор бүрэн хангаж, спорт зааланд цагийн хувиараар тоглуулж дасгалжуулан, шаардагдах медаль цом болон бусад зүйлсийг бэлтгэн амжилттай зохион байгуулж ажилласан.	IV, IX	100
Үнэлгээ: 96.6 хувь							

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1. Монгол бичиг, англи хэлний мэдлэг чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдах	Гэрчилгээний тоо	-	2	Монгол бичгийн хичээлийг бие даан суралцаж байна.	I-IX	70
2.	Арга хэмжээ 2.2. Мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулдаг тасралтгүй боловсролын багц сургалтад хамрагдах.	Гэрчилгээ, сертификатын тоо	1	1	-Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулж буй "Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2024" 47 төрлийн хичээл, 40 кт цагийн онлайн сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн хамрагдаж эхэлсэн бөгөөд тус сургалт нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болох тул мэргэшсэн нягтлан бодогчийн үүргийн биелэлтийг хангахаар төлөвлөн суралцаж байна. -Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн эрхэлсэн түшмэлийн 9 багц сургалтыг амжилттай дүүргэж, E1509 тоот сертификатыг авсан.	I-IX	100
Үнэлгээ: 85 хувь							

Төлөвлөгөөг үнэлсэн:
ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
Н.УУГАНБАЯР
(огноо)
.....